# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХОЙД БҮС ДЭХ ГАЗРЫН 2019 ОНЫ АРАВДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/2019.09.26-2019.10.25/

2019 оны 10 дугаар сарын 26 Сүхбаатар сум

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин | Хариуцах албан хаагч | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Хяналт шалгалтын чиглэлээр | Газрын хэмжээнд оршин сууж буй гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх, үр дүнгийн талаар удирдлагад танилцуулах | Газрын хэмжээнд оршин сууж буй гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх, үр дүнгийн талаар удирдлагад танилцуулсан байна. | Хяналтын улсын ахлах байцаагч, хяналтын улсын байцаагч нар | Тайлангийн хугацаанд зөрчлийн хэрэг нээгээгүй. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 22 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн байна.<br>Зөрчлийн тухай хуулиар зөрчил гаргасан 6 орны 18 иргэнд 1.840.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд: АНУ-1, Франц-1, БНХАУ-3, Украйн-1, ОХУ-10, Бразил-2 иргэн байна.<br>Гадаадын иргэний урьсан 3 аж ахуй нэгж, байгууллагад 670.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. | 100 |
| 2 | | Сүхбаатар төмөр зам, Алтанбулаг авто замын боомтод Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шийдвэрлэсэн хяналтын улсын байцаагчийн материалд шалгалт хийж бүсийн газрын даргад танилцуулан прокурорт хянуулах | Холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байх, газрын даргад танилцуулан, үр дүнг прокурорт хянуулсан байна. | Хяналтын улсын ахлах байцаагч С.Мөнх-Эрдэнэ | 2019.09.26-наас 2019.10.25-ны хугацаанд нийт 22 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, харьяа Прокурорын газрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хяналтанд оруулах ажиллагааг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 3 | | Барилга, зам гүүр, тээвэр, тоосго, төмөрлөгийн үйлдвэрүүд болон | Барилга, зам гүүр, тээвэр, тоосго, төмөрлөгийн үйлдвэрүүд болон аялал | Хяналтын улсын ахлах байцаагч, хяналтын | Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар:<br>Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 1-05/10 дугаар удирдамжийн хүрээнд Хойд бүс дэх газрын даргын баталсан ХБГ-14/18 дугаар удирдамжийн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллаж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллаж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийгдсэн байна. | улсын байцаагч нар | дагуу 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 25-ны өдрийн хооронд уул уурхай, барилга, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр 34 аж ахуй нэгж, байгууллагын 6 орны 414 иргэний бичиг баримтад хяналт шалгалт хийсэн. дараах хяналт шалгалтыг зохион байгууллаа. Үүнд: Сэлэнгэ аймгийн Хүдэр сум, Булагтай 1 дүгээр баг, “Эрдэс холдинг” ХХК-ийн нойтон хүдэр баяжуулах үйлдвэрийн талбайд 09 дүгээр сарын 23-ны өдөр хийсэн хяналт шалгалтаар БНХАУ-ын иргэн Yang Changbo, Yang Changtao нар нь 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр “J” ангиллын 30 хоногийн байх хугацаатай, нэг удаагийн орох зориулалттай визтэй Замын-Үүд авто замын боомтоор орж ирэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болох нь Yang Changbo, Yang Changtao нарын гадаад паспорт дахь MNG0133818, MNG0133819 дугаартай виз болон зөрчлөө хүлээн зөвшөөрөн бичгээр гаргасан тайлбар, хяналт шалгалтын явцад авсан фото зураг зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож байна. БНХАУ-ын иргэн Yang Changbo, Yang Changtao нарын Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн үйлдэлд нь Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт зааснаар тус бүр 100,000 /нэг зуун мянган/ төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.7-д тус тус зааснаар 3 жилийн хугацаанд орох эрхгүйгээр Монгол Улсаас албадан гаргах саналыг хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.<br>Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/270 дугаар захирамжийн дагуу 08 дугаар сарын 21-ний өдрөөс | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 31-ний өдрийн хооронд хууль, хяналтын байгууллагуудын хамтарсан хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж, нөхөрлөлийг албадан буулгах, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэх ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн бөгөөд хууль бусаар үйл ажиллагаа явуулж байсан иргэн, аж ахуй нэгж, компани, нөхөрлөлүүдийн хүнд машин механизм, техник, хэрэгслүүдийг лацдаж, битүүмжилсэн болно.<br>Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар:<br>Хойд бүс дэх газрын даргын баталсан 14/15 тоот удирдамжийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хяналтын улсын байцаагч Б.Ганзориг, сүлжээний инженер Э.Наранбат, Сэлэнгэ аймаг дахь тагнуулийн газрын ажилтан а/д н.Ганбаяр нарын бүрэлдэхүүнтэй Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Нарангийн гол гэх газарт байрлах Угалз хөндий хоршоонд БНХАУ-ын иргэд хууль бусаар ажиллаж байна гэсэн мэдээллийн дагуу тухайн газарт Сэлэнгэ аймаг дахь тагнуулийн газрын ажилтан а/д н.Ганбаяр, сүлжээний инженер Э.Наранбаттай цуг БНХАУ-ын 3 иргэний баримт бичгийг шалгахад БНХАУ-ын иргэн Yan Shoudei нь “J” ангиллын визтэй , БНХАУ-ын иргэн Kong Wuhai нь B ангиллын визтэйгээр 2019 оны 10 дугаар сарын 14 өдөр Замын-Үүдийн төмөр замын боомтоор хил нэвтрэн орж ирсэн. БНХАУ-ын иргэн YAN SHOUDEI , KONG WUHAI нартай холбогдох хэргийн ажиллагааг явуулж байна. | |
| 4 | Өргөдөл, гомдлын чиглэлээр | Сүхбаатар төмөр зам, Алтанбулаг авто замын боомтод Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил | Холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байх, газрын даргад танилцуулан, үр дүнг прокурорт хянуулсан байна. | Хяналтын улсын ахлах байцаагч, захиргааны мэргэжилтэн | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл байхгүй. Газрын албан хаагчдаас чөлөө хүссэн 4 өргөдлийг газрын дарга тухай бүр танилцаж шийдвэрлэсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | шийдвэрлэсэн хяналтын улсын байцаагчийн материалд шалгалт хийж бүсийн газрын даргад танилцуулан прокурорт хянуулах | | | | |
| 5 | Виз бүртгэлийн чиглэлээр | Виз олгохдоо холбогдох баримт бичгийн бүрдлийг бүрэн хангуулж, Монгол Улсад нэвтрэх шаардлагыг тогтоох ярилцлагыг хийн, мэдээллийг “ISM” цахим мэдээллийн сангаас сайтар нягталсны үндсэн дээр олгож байх | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн Газрын 145 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна. | Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтнүүд | Газрын хэмжээнд 2019 оны 09 дугаар сарын 26-ны өдрөөс 10 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу 20 орны 65 иргэнд зохих ангилал, зориулалтын визийг зохих зөвшөөрлөөр олгож ажиллаа. Үүнд: АНУ-1, Бельги-6, Азербайжан-6, Бангладеш-12, Болгар-1, БНКазУ-1, Литва-1, БНМолдав-3, Польш-1, БНСУ-1, Филиппин-1, Франц-2, БНХАУ-8, ӨАБНУ-1, Иран-2, Испани-7, ИБУИНВУ-5, ОХУ-7, Португаль-1, ХБНГУ-1, Швейцарь-1 иргэн байна. Олгосон визийг төрөл, зориулалтаар нь авч үзвэл: нэг удаагийн орох виз-44, нэг удаагийн гарах-орох виз-7, дамжин өнгөрөх виз-14 байна.<br>Визийн хураамж 5,544,000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан. | 100 |
| 6 | | Хил орчмын нутаг дэвсгэрт зорчиж буй гадаадын иргэдэд хяналт тавих | Хилийн боомт болон Монгол-ОХУ-ын хилийг хялбаршуулсан журмаар нэвтрэх тухай Монгол-Оросын Засгийн Газар хоорондын гэрээ, хэлэлцээрт нийцсэн байна. | Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч нар | Хялбарчилсан журмаар хил орчмын нутагт зорчих үнэмлэхтэй ОХУ-ын 96 иргэнд бүртгэл хийсэн. | 100 |
| 7 | | Түр ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, | Төрийн үйлчилгээг гадаадын иргэдэд түргэн шуурхай үзүүлсэн байна. | Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын | Тайлант хугацаанд 8 орны 44 иргэнд бүртгэл, хасалт хийн, бүртгэлийн хураамж 61,000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Үүнд: АНУ-3, Азербайжан-1, БНХАУ-18, Иран-2, Кыргыз-1, ОХУ-16, Украйн-2, Бразил-1 иргэн байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагаас гаргасан хүсэлтийг зохих удирдлагад мэдэгдэн хуулийн дагуу шуурхай шийдвэрлэн, бүртгэл хөтөлж, ISM программын мэдээллийн санд оруулан баяжилт хийх | | улсын байцаагч нар | | |
| 8 | | Хилийн боомтод ашиглагдаж байгаа үнэт цаасны тооцоог гаргаж нягтлангаар хянуулж ажиллах | Албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа үнэт цаасны тооцоог гарган сарын 02-ны өдөр ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн байна. | Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч, мэргэжилтнүүд | Алтанбулаг, Сүхбаатар боомтуудад ашиглагдаж буй үнэт цаасны 9 дүгээр сарын тайланг гарган, ахлах нягтлан бодогчид хянуулж ажилласан. | 100 |
| 9 | Захиргаа, хүний нөөцийн чиглэлээр | Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал шийдвэр, Хойд бүс дэх газрын 10 дугаар сарын үйл ажиллагааны тайлан, үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг зохих газарт хүргэн ажиллах | Тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд авч, нэгтгэн Хяналт, шинжилгээ дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна. | Захиргааны мэргэжилтэн Г.Ариунзаяа | Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу тус газрын 10 дугаар сарын нэгдсэн үйл ажиллагааны тайлан, 10 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтийг 10 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон, 10 дугаар сард хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 10 дугаар сарын 26-ны өдөр газрын даргаар батлуулан Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлж ажиллаа. | 100 |
| 10 | | Жолооч нарт тээврийн хэрэгслийн | Тус газрын жолооч нарыг сар бүр аюулгүй арга хэмжээний | | Тус газрын жолооч З.Баатархүү, Э.Уганбаяр нарт тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал,ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгт холбогдох дүрэм, журам, аюулгүй арга хэмжээний зааварчилгааг танилцуулан хэрэгжилтийг хангуулан ажиллах | зааварчилгаатай танилцуулан бүртгэл хөтөлсөн байна. | | холбогдох дүрэм, журам, аюулгүй арга хэмжээний зааварчилгааг 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдөр танилцуулан, гарын үсгээр баталгаажуулж ажиллсан. | |
| 11 | | Газрын нийт албан хаагчдын 11 дүгээр сарын цагийн тооцоог гаргах, ажлын цаг ашиглалтанд хяналт тавьж бүртгэл хөтлөн ажиллах | Албан хаагчдын цалин хөлс хугацаандаа олгогдсон байна. Албан хаагчдын цагийн бүртгэлийг хуваарийн дагуу хөтлөсөн байна. | Захиргааны мэргэжилтэн Г.Ариунзаяа | Тус газрын төв болон төлөөллүүдийн ажлын цагийг ажлын өдрүүдэд өдөр бүр 09:00 цагаас 18:00 цагийн хооронд бүртгэн хяналт тавьж ажиллаж хэвшсэн бөгөөд Алтанбулаг авто зам, Ханх авто зам, Сүхбаатар төмөр замын боомтод хуваарийн дагуу ажиллаж байгаа албан хаагчдын цагийн бүртгэлийг байгууллагын даргын баталсан хуваарийн дагуу хөтөлсөн. Албан хаагчдын 10 дугаар сарын цагийн бүртгэлийн тооцоог гарган 10 дугаар сарын 24-ний өдөр газрын даргын Б/13 “Төрийн үйлчилгээний албан хаагчдад 10 дугаар сарын ур чадварын нэмэгдэл олгох тухай” тушаалын хамт ахлах нягтлан бодогч Б.Тунгалагтуяад хүргүүлж ажиллаа. | 100 |
| 12 | Санхүү хангалтын чиглэлээр | Сарын батлагдсан төсвийн хүрээнд аймгийн төрийн санд холбогдох гүйлгээг хийн өр авлагагүй ажиллах, сарын цалинг 10,25-ны дотор бодож олгох | Сарын батлагдсан төсвийн хүрээнд аймгийн төрийн санд холбогдох гүйлгээг хийн өр авлагагүй ажиллах, сарын цалинг тухайн сарын 10,25-ны өдрийн дотор бодож олгосон байна. | Ахлах нягтлан бодогч Б.Тунгалагтуяа | Тус газар нь 10 дугаар сард 41,9 сая төгрөгийн санхүүжилт авч нийт аймгийн төрийн санд нийт 17 төрлийн нийт 49 гүйлгээг хийж нийт 68%-н гүйцэтгэлтэй ажилласан. Мөн албан хаагчдын цалин хөлсийг 4, 24 өдөр бодож олгон өр авлагагүй ажиллаж байна. | 100 |
| 13 | | Газрын 9 дүгээр сарын бараа | Газрын 9 дүгээр сарын бараа материал, | Ахлах нягтлан бодогч | Газрын 09 дүгээр сарын бараа материалын орлого зарлагын тайлан, шатахууны тайланг нярав нэгтгэн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | материал, шатахуун, үнэт цаасны тайланг холбогдох албан тушаалтнаар гаргуулан нэгтгэж , сарын 2-ны гүйцэтгэлийн мэдээ, 3 дугаар улирлын тайланг нэгтгэн гаргаж Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлэх, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаал, журмаар сургалт орох | шатахуун, үнэт цаасны тайланг холбогдох албан тушаалтнаар гаргуулан нэгтгэж, сарын 2-ны гүйцэтгэлийн мэдээ, тайланг нэгтгэж Санхүү, хангалт үйлчилгээний газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. | Б.Тунгалагтуяа | гаргаж, үнэт цаасны тайланг Хяналтын улсын ахлах байцаагчаас нэгтгэн гаргуулж, сарын мэдээ, тайланг нэгтгэн гаргаж хуульд заасан хугацаанд Гадаадын иргэн, харьяатын газрын Санхүү, хангалт үйлчилгээний газарт хугацаанд нь хүргүүлж ажилласан. | |
| 14 | | Шилэн дансны шинэ веб сайтад газрын санхүүгийн 9 дүгээр сарын мэдээллийг байршуулан, сарын шилэн дансны мэдээг ГИХГ-н Санхүү хангалт үйлчилгээний газарт хүргүүлэх | Газрын санхүүгийн 09 дүгээр сарын мэдээг Санхүү хангалт үйлчилгээний газарт хүргүүлж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна. | Ахлах нягтлан бодогч Б.Тунгалагтуяа | Тус газар нь 09 дүгээр сард шилэн дансны сайтад шилэн дансны хуулинд заасан мэдээлэл болох 13 төрлийн мэдээ тайланг хугацаанд нь байршуулан хоцрогдолгүй ажиллаа. | 100 |
| 15 | | Байгууллагын нийгмийн даатгал болон татварын тайланг хийн 2019 оны 09 дүгээр сарын байдлаар гарган холбогдох сайтуудад | Газрын албан хаагчдын нийгмийн даатгал болон татварын тайланг 2019 оны 09 дүгээр сарын байдлаар гарган холбогдох сайтуудад байршуулсан байна. | Ахлах нягтлан бодогч Б.Тунгалагтуяа | Байгууллагын 09 дүгээр сарын нийгмийн даатгал, татварын тайланг хуулийн хугацаанд холбогдох сайтад байршуулан нийт 24 албан хаагчийн нийгмийн даатгал эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийн ажиллаа. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | байршуулах, нийгмийн даатгал эрүүл мэндийн даатгалын дэвтэрт бичилт хийн баталгаажуулах | | | | |
| 16 | Мэдээлэл технологийн чиглэлээр | Сүлжээний аюулгүй байдал, нууцлалыг хангах, мэдээлэл сүлжээний тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна. | Сүлжээний инженер Э.Наранбат | Тайлант хугацаанд нийт 7 удаагийн сүлжээний тасралтыг дуудлагаар хүлээн авч Алтанбулаг авто зам, Сүхбаатар төмөр замын боомтод ажиллаа. | 100 |
| 17 | | Албаны үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгслийн хүчин чадалд үзлэг хийх | Газрын тоног төхөөрөмжүүд болон кабель шугамууд хэвийн ажиллагаатай байна. | | Газрын хэмжээнд ашиглагдаж буй дотоод сүлжээний 2 удаагийн тасралтыг гэмтлийг Хилийн цэргийн 101-р ангийн инженерийн хамт 10 дугаар сарын 20, 27-ний өдрүүдэд засварлаж ажиллаа. | 100 |
| 18 | | Байгууллагын веб сайтад сарын онцлох мэдээ, мэдээллийг тухай бүр оруулах, техник төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг сайжруулах, төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн сайтад 10 дугаар сарын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг оруулах | Байгууллагын вэб сайтад энэ сарын тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, бусад холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудас /www.immigration.gov.mn/ сайтад байршуулсан байна. Мөн төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн сайтад 10 дугаар сарын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг оруулсан байна. | Захиргааны мэргэжилтэн, сүлжээний инженер | Байгууллагын /www.immigration.gov.mn/ вэб сайтад 10 дугаар сарын тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хугацаанд нь байршуулж ажиллаа. Мөн төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системийн /hr.csc.gov.mn/ сайтад бүрэлдэхүүн хөдөлгөөний 10 дугаар сарын мэдээллийг 10 дугаар сарын 25-ны өдөр оруулж ажиллаа. | 100 |

Биелсэн 18
Хагас биелсэн 0
Биелээгүй 0
Нийт 18 ажил төлөвлөснөөс 100 хувьтай.